

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХИЙХ
АЖЛЫН УДИРДАМЖ

2022.04.04

№ 02

Чойр

Байгууллагад хэрэгжиж байгаа шилэн дансны тухай
хуулийн хэрэгжилтэнд шалгалт хийх тухай

Нэг. Зорилго

2022 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 1 дүгээр улирлын байдлаар байгууллагын шилэн дансны цахимд байршуулсан мэдээлэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахад чиглэнэ.

Хоёр. Хамрах хүрээ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 1 дүгээр улирлын шилэн дансны цахимд байршуулсан мэдээллийн хөтлөлт, үр дүнг сайжруулахад чиглэсэн хяналт- шинжилгээг хийх, зөвлөмж өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийх хугацаа, шалгалт хийх багийн бүрэлдэхүүн

Хяналт- шинжилгээ, үнэлгээг 2022 оны 04 дүгээр сарын 05 –ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн С.Мөнхжаргал, дотоод хяналт шалгалтын багийн гишүүн Т.Түвшинзаяа, А.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, ХХААХҮСайдын 2017 оны А\159 дүгээр тушаалын хэрэгжилт, дотоод аудитыг Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолыг удирдлага болгон гүйцэтгэнэ.

Тав. Хяналт-шинжилгээ үнэлгээний үр дүнг тайлагнах

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн тухай гүйцэтгэлийн үнэлгээ, дүгнэлтийг холбогдох албан тушаалтанд танилцуулна.

Хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг ХХААГ-ын даргын зөвлөлд 2022 оны 04 дүгээр сарын 14-нд танилцуулж, шийдвэрийг гаргуулан, гүйцэтгэлд хяналт тавина.